

ЕВРОПЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

*Д.Золбоо**

Манай хүрээлэнгээс 2010 онд “Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого ба хүрээлэн буй бүс нутгуудад бүрэлдэн буй хамтын ажиллагааны механизмууд” сэдэвт ажлын хүрээнд “Европын Холбоо ба Монгол Улсын хамтын ажиллагааны механизмууд” дэд сэдвийн төлөвлөгөө боловсруулж холбогдох судалгааны ажил хийхээр үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Энэ сэдвийн хүрээнд Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага болон Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагыг сонгон авч мэдээлэл боловсруулж байна. Бэлтгэсэн мэдээллийн эхлэл болгон ЕАБХАБ-ын талаарх товч танилцууль.

ЕАБХАБ нь НҮБ-ын Үндсэн дүрмийн VIII бүлэгт заасны дагуу зөрчилдөөнөөс сэргийлэх, урьдчилан сэрэмжлүүлэх, хямралын менежмент болон учирсан зөрчилдөөний хор холбогдлыг арилгах чиглэлээр анхааран ажилладаг НҮБ-ын Ерөнхий Ассемблейд ажиглагчын статустай оролцдог дэлхийн хамгийн том аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Засгийн газар хоорондын байгууллага юм. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь галт зэвсгийн хяналт, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө болон шударга сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих явдал юм.

Өнөөдөр энэ байгууллагад Европ, Кавказ, Төв Ази болон Умард Америкийн 56 улс орон гишүүнээр багтаж дэлхийн бөмбөрцгийн хойд хэсгийн газар нутгийн ихэнхийг хамарч байна

Түүх: Энэ байгууллагын анхны үүсэл нь 1973 он буюу “Хүйтэн дайн”-ы үед байгуулагдсан Дорно-Өрний форум буюу Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлаас (ЕАБХАБХ буюу CSCE) эхлэлтэй. 1950-аад оны дунд үеэс эхлэн энэ сэдвээр яригдаж байсан боловч Европын аюулгүй байдлын байгууллагын сураг Хүйтэн дайны уршгаар амжилтанд хүрэлгүй байсаар 1972 оны 11 дүгээр сард Хельсинк хотноо болсон яриа хэлэлцээрийн дүнд идэвхижсэн байна. Яриа хэлэлцээрийн ерөнхий уур амьсгал бүс нутаг дахь түгшүүртэй байдлыг намжаах, цаашлаад эдийн засгийн хамтын ажиллагаа болон Коммунист дэглэмтэй улс орнууд дахь хүмүүнлэгийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэж байсан хэдий ч Зөвлөлт Холбоот Улсын зүгээс Дорнод Европын коммунист улсууд төдийгүй Өрнөд Европын улс орнууд дахь өөрийн хяналтаа хадгалах зорилгыг агуулж байсан гэж үзэх нь бий.

Яриа хэлэлцээний үр дүнд Хельсинкийн үйл хэргийг үргэлжлүүлэх гурван үе шат бүхий бага хурал зохион байгуулах “Хөх ном”-ыг гаргажээ. Нийт 35 улсын төлөөлөгч оролцсон бага хурал 1973 оны 7 дугаар сард Хельсинк хотноо нээгдэж эхний үе шат нь таван хоног үргэлжлэн “Хөх ном”-ыг баталжээ. Хоёрдугаар үе шат нь 1973 оны 9 дүгээр сард Женев

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

хотод эхэлсэн бага хурлын үр дүнд Хельсинкийн төгсгөлийн баримт бичгийг боловсруулан 1975 онд оролцогч 35 улс орны төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулжээ.

Төгсгөлийн баримт бичигт цэрэг-улс төр, эдийн засаг ба байгаль орчин, хүний эрхийн асуудлаар Европ тивийн улс орнуудын хүлээх үндсэн үүрэг тусгагдсаны дээр тэдгээр орны төр засгийн зүгээс өөрсдийн иргэд болон улс хоорондын харилцаанд баримтлах зарчмуудыг тодорхойлсон.

Харилцаа холбоог сайжруулах талаарх үзэл баримтлал болон Баримт бичгийн хэрэгжилтийн явцад Белград (1977-1978), Мадрид (1980-1983), Вена (1986-1989) хотуудад болж байсан ээлжит уулзалт ярилцлага багагүй үүрэг гүйцэтгэжээ.

1990-ээд оны эхээр коммунист лагерь тэр дундаа ЗХУ-ын задрал нь ЕАБХАБХ-ын үүрэг ач холбогдлыг өөрчлөхийг шаардсан байна. Европын улсууд, болон Канад, АНУ, ЗХУ зэрэг улсууд хамтран гаргаж 1990 оны 11 сард гарын үсэг зурсан Шинэ Европын төлөөх Парисын тунхаглал энэхүү өөрчлөлтийн эхлэлийг тавьсан юм. Өөрчлөлтийн хүрээнд 1994 онд Будапешт хотноо болсон хурлын шийдвэрээр 1995 оны 1 дүгээр сараас ЕАБХАБХ-ын нэрийг ЕАБХАБ болгон өөрчлөн баталжээ.

Бүтэц зохион байгуулалт: Өнөөдөр ЕАБХАБ нь нарийн бичгийн дарга нарын газар, Удирдлагын зөвлөл, Парламентын хуралдаан, Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх төв, Чөлөөт сонгуулийн газар (Ардчиллын хүрээлэн ба хүний эрхийн газар) гэсэн үндсэн зохион байгуулалттай ажилладаг байна. 1996 оны 12 сард батлагдсан “XXI зууны Европын нийтлэг болон өргөн хүрээтэй аюулгүй байдлын загварын Лиссабоны тунхаглал”-аар Европ тивийн аюулгүй байдлын хуваагдашгүй байдлын талаар бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн юм.

1999 онд Станбул хотод болсон хуралдаанаар “Европын аюулгүй байдлын тунхаглал”-ыг баталжээ.

Уг байгууллагыг гишүүн улсууд ээлжлэн удирддаг бөгөөд өнөөдрийн байдлаар ЕАБХАБ –ыг Казахстан улс толгойлж байна.

Байнгын зөвлөл, Аюулгүй байдлын хамтын ажиллагааны форум, Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгчийн газрууд Вена хотод, Ардчиллын хүрээлэн болон хүний эрхийн газар нь Варшавт, Үндэсний цөөнхийн дээд комиссар Гаага хотод, Парламентын ассамблей Копенгаген хотод тус тус төвлөрөн байрлаж ойролцоогоор 400 орчим хүн ажилладаг байна.

Парламентын ассамблей нь улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, хүрээлэн буй орчин, ардчилал хийгээд хүний эрхийн холбогдолтой асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах эрх бүхий байгууллага юм. Гишүүн орнуудын төлөөллийн дуу хоолойг илэрхийлдэгийнхээ хувьд эндээс гарсан тогтоол шийдвэрийг гишүүн улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй. Түүнээс гадна парламентийн дипломат бодлого болон өргөн хүрээнд сонгуулийн үйл ажиллагаа ажиглалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг юм.

ЕАБХАБ-ын хамгийн анхны бүтэц зохион байгуулалтын нэг болох Ардчиллын хүрээлэн болон хүний эрхийн газар нь 1990 оны Парисын хуралдааны үр дүнд 1991 онд анх байгуулагдсан. 1995 оноос хойш нийтдээ 150 гаруй удаагийн сонгуулийн үйл ажиллагаанд 3500 орчим ажиглагчдыг илгээсэн байна. Өөрийн хариуцсан бүс нутгаас гадна 2 удаагийн сонгуульд ажиглагчаа илгээж байсан нь Афганистаны 2004 оны 10 сард болсон Ерөнхийлөгч, 2005 оны 9 сарын парламентын болон орон нутгийн сонгууль юм.

Харин бүс нутаг дахь үйл ажиллагаа нь төлөөлөгчийн газраараа дамжуулан хэрэгждэг. Үүнд: Өмнөд Кавказад: Баку, Ереван хот: Төв Азид: Акхабад, Астана, Бишкек, Тажикстан, Узбекистан: Зүүн Европт: Минск, Молдав, Украин: Зүүн Өмнөд Европт: Албани, Косово, Монтенегро, Серб, Скопје, Загреб гэсэн газруудад нийтдээ 3000 орчим ажилтан албан хаагчтайгаас ихэнх нь орон нутгийн иргэд байдаг байна.

Дараагийн удаад Монгол Улсаас энэ байгууллагатай хамтран ажиллаж байгаа өнөөгийн байдал, хэтийн чиг хандлагын талаар танилцуулах болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. <http://www.osce.org/>
2. <http://en.wikipedia.org/wiki/OSCE>
3. Charter for European security. Istanbul, November 1999
4. The OSCE Magazine OSCE Summits in changing times Issue Number 4/2010
5. <http://www.mfat.gov.mn/>